

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

ХОРООДЫН ЗАСАГ ДАРГА, АЖЛЫН АЛБА

Хороодын Засаг дарга, түүний ажлын алба нь төрийн үйлчилгээ, төр засгийн хууль тогтоомжийг гэгдэд хүргэх төрийн захиргааны анхан шатны нэгж юм.

1-р хороо 2630 өрхийн
9725 хүн амтай. Хорооны
Засаг дарга Д.Хандбадам
Утас : 631553

2-р хороо 1073 өрхийн
5115 хүн амтай.
Хорооны Засаг дарга
Н.Чулуунбаатар
Утас : 632668

3-р хороо 2520 өрхийн
11629 хүн амтай. Хорооны
Засаг дарга Г.Цэрэндулам
Утас : 631836

4-р хороо 2122 өрхийн
11238 хүн амтай. Хорооны
Засаг дарга Д.Ганболд
Утас : 631027

5-р хороо 2322 өрхийн
10489 хүн амтай.
Хорооны Засаг дарга
Д.Норолхоосүрэн Утас :
632957

6-р хороо 1665 өрхийн
9725 хүн амтай. Хорооны
Засаг дарга Б.Болдбаатар
Утас : 632688

7-р хороо 2510 өрхийн
15242 хүн амтай. Хорооны
Засаг дарга Д.Мөнхцэцэг
Утас : 631015

8-р хороо 1506 өрхийн
7446 хүн амтай. Хорооны
Засаг дарга Э.Буянхүү
Утас : 636113

9-р хороо 1772 өрхийн
14726 хүн амтай. Хорооны
Засаг дарга С.Өлзийсайхан
Утас : 306074

10-р хороо 2381 өрхийн
11570 хүн амтай. Хорооны
Засаг дарга С.Алдармаа
Утас : 306080

11-р хороо 2341 өрхийн
10719 хүн амтай. Хорооны
Засаг дарга Ж.Сүнчинсүрэн
Утас : 306011

12-р хороо 1975 өрхийн
6976 хүн амтай. Хорооны
Засаг дарга М.Баасанхүү
Утас : 683133

13-р хороо 1669 өрхийн
7157 хүн амтай. Хорооны
Засаг дарга Г.Гүнжилмаа
Утас : 682744

14-р хороо 1970 өрхийн
8691 хүн амтай. Хорооны
Засаг дарга Б.Ганчимэг
Утас : 682763

15-р хороо 1679 өрхийн
7913 хүн амтай. Хорооны
Засаг дарга Ч.Наранцэцэг
Утас : 682927

16-р хороо 1565 өрхийн
7035 хүн амтай. Хорооны
Засаг дарга Я.Өлзийдэлгэр
Утас : 681076

17-р хороо 1541 өрхийн
6846 хүн амтай. Хорооны
Засаг дарга Ч.Лүмэдмаа
Утас : 681559

18-р хороо 2159 өрхийн
10258 хүн амтай. Хорооны
Засаг дарга Ш.Бурмаа Утас
: 632600

19-р хороо 1901 өрхийн
9870 хүн амтай. Хорооны
Засаг дарга Б.Дуламжав
Утас : 632510

20-р хороо 2070 өрхийн
9184 хүн амтай. Хорооны
Засаг дарга С.Мөнхбат
Утас : 631237

21-р хороо 1556 өрхийн
5032 хүн амтай. Хорооны
Засаг дарга С.Ядам Утас :
631041

22-р хороо 2430 өрхийн
8965 хүн амтай. Хорооны
Засаг дарга Д.Польхүү
Утас : 631847


23-р хороо 1820 өрхийн
7613 хүн амтай. Хорооны
Засаг дарга Д.Чинбат
Утас : 632007

24-р хороо 1110 өрхийн
4680 хүн амтай. Хорооны
Засаг дарга Л.Төмөрбаатар
Утас : 631361

25-р хороо 1753 өрхийн
6930 хүн амтай. Хорооны
Засаг дарга Ц.Цэнд-аюуш
Утас : 306008

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

МАНАЙ ӨНГӨ ТӨРХ



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ



ИРЭЭДҮЙН ӨНГӨ ТӨРХ





1. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга санаачлагаар журмын дагуу баталсан ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хот төлөвлөлт эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээнд 1998-2000 онд боловсруулжээ.

Энэ ерөнхий төлөвлөгөөнд Улаанбаатар хотыг хөгжлийг баруун тийш Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хотын төвийг шилжүүлэх мөн шинээр орон сууцнууд, амины орон сууцны хороолол баригдахаар тусгагдсан.

2. Баянголын аманд баригдах Орбит, Баянгол хотхоны өнөөгийн байдал, цаашид барилгажих ерөнхий төлөвлөгөө, хэтийн төлөвийн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын загвар макетийг үзүүлье.

Нийт 100.0 га талбайд 10.000 хүнтэй хороолол баригдах юм.

3. Мал бордох талбайн орчимд нийт 765.0 га талбайд 30.000 гаруй мянган хүнтэй хотхон байгуулагдах юм.




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

МАНАЙ ДОМОГ ХУУЧ

Сонгинохайрхан дүүргийн нутагт эрт эдүгээгийн түүхийн улбаа, жимийг хадгалсан дурсгалт газар олон бий. Сонгино хайрхан ууланд Хүннү, Сүннүгийн хиргэсүүр булш олон байдаг. 1988 онд энэ уулын өвөрт нэгэн булшинд малталт хийхэд сумны зэв, дуут товруу, суран бүсний үзүүрийн алтан чимэг зэрэг эд өлгийн зүйлс гарчээ. Эдгээрийг судалсан эрдэмтэд 13 дугаар зууны үеийн үйл явдал, ялангуяа Чингис хаан болон Жамуха нартай ямар нэгэн холбоотой байж магадгүй гэсэн таамаглал дэвшүүлсэн юм.

Их Хүрээ 1839 онд Толгойтын аманд нүүн ирж 16 жил болсон байна. Түвдийн 13 дугаар Далай лам Түвдэнжамц 1904 онд Их Хүрээнд ирэхдээ эдүгээгийн Сонгинохайрхан дүүргийн нутагт анхлан бууж алжаал юугаа тайлсан гэдэг. Одоогийн Жаргалант тосгон буюу Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг, Хүй долоон худагт Богд хаанд Бат оршил өргөх долоон хошуу даншиг наадам болдог байсан түүхтэй. Даншиг наадмын хурдан морины уралдааныг үзэхээр Богд хаан бараа бологсдын хамт морилон ирдэг байжээ. Мөн Толгойтын давааны ар бэлд жанжин Д.Сүхбаатар цэргийн штабын хамт Нийслэл Хүрээг чөлөөлөхийн өмнө 1921 оны долдугаар сарын долоон, найманд хоноглож байсан байна. Энэ мэт өнө эртний хийгээд өнгөрсөн зууны эхэн үеийн үйл явдалтай холбоотой түүхийн улбаа мөрийг хадгалсан газар нутгийн талаар цухас өгүүлсүү.

Сонгинохайрхан - содон уул



Нийслэл Улаанбаатар хотын баруун захад орших эртний тахилгат Сонгино хайрханы ноён оргил нь далайн төвшнөөс дээш 1663 метр өндөр өргөгдсөн. Сонгинохайрхан уул нь алаг өвс, бутуулт хялгана зэрэг өргөн тархацтай ургамалтай. Энэ уул Улаанбаатар хотын баруун этгээдэд, Туул голын хойд биед орших бөгөөд өнө эртнээс шүтэн дээдэлж ирсэн тахилга сүлдэт уул билээ. Хад асгатай, хайлаас харгана ихтэй, агь ганга, цагаан төмс, гандигар мод зэрэг эмийн ургамал ургадагаараа алдаршсан. Галт хар үнэгтэй учир өвөл цасгүй хар өвөлждөг гэсэн домогтой.

Сонгинохайрхан дүүргийн нутагт 1652 метр өндөр Дарцагт, 1520 метр өндөр Баян-Өндөр, Майхан толгой, Соёлд уул, Таширын нуруу, Улаан ямаат, 1691 метр өндөр Тахилт уулууд оршино.

Чингис хаан Арслан савдагт уулыг

Сонгинохайрхан хэмээн нэрлэсэн нь

Улаанбаатар хотын дөрвөн талд орших тахилга шүтлэгт дөрвөн хайрхан Богд уул /хамгийн өндөр цэг нь 2265 м/, Сонгинохайрхан /оргил нь 1663 м/, Чингэлтэй /1831 м/, Баянзүрх /1846 м/ нь тус тусдаа сан тахилгын судартай ч дөрвүүлийг нэгтгэн тахихаар зохиосон хураангуй судар ихэд тархжээ. Зөвхөн дөрвөн уул төдийгүй Хан уулын ард орших Зэндмэнэ уул, Хатан Туулыг ч энэ судраар тахиж болдог байна.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

Монголын түүхэнд эртнээс алдартай дөрвөн уулын энэхүү хураангуй судар ихэд дэлгэрсэн байдаг бөгөөд дөрвөн уулын тухай олон сайхан домог хууч өнөөг хүртэл уламжлагдан иржээ. Тэдгээрээс нэгийг өгүүлбээс Чингис хаан есөн өрлөг, 13 баатрынхаа хамт Алтан тэвшийн хөндийд буюу Хүн чулууны хонхорт нэг удаа саатан морилжээ. Хаантан бээр дөрвөн зүгт нь сүндэрлэх дөрвөн уулыг сонжин шинжин ажаад тус бүрт нь нэр хайрласан гэнэ. Тэр үед дөрвөн уул тухайлсан нэргүй байсан аж. Чингис хаан дөрвөн уулыг нар зөв эргэж Хан уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Цэнгэлтэй хэмээн нэрлэсэн нь цөм учиртай байжээ. Үүнээс өмнө дөрвөн уулыг Хан гарди /Хан уул/, Арслан /Сонгинохайрхан/, Луу /Цэнгэлтэй хайрхан/, Бар /Баянзүрх уул/ гэж савдагаар нь нэрлэж байсан гэнэ.

Чингис хаан Арслан савдагтай хайрханд явж байтал арслан архирах шиг дуун гарч, хад асга нурж их эзний өлмийд том сонгино өнхөрч ирээд тогтсонд уг уулыг Сонгинохайрхан хэмээн нэрийдсэн гэх домогтой. Энэчлэн бусад уулыг нэрлэсэн тухай өөр өөр домгууд ч бий.

Өндөр хайрханы сан сэржмийг зохиосон тухай

Дөрвөн уулын тахилгын сударт Сонгинохайрхан уулыг Зонжаа гэж төвдөөр орчуулсны дээр бас Өндөр хайрхан гэж өргөмж нэрээр нэрлэсэн байна. Сонгинохайрхан уулыг бүрэн зэвсгээ авсан их баатар эр, цэргийн жанжин зэрэг олон шинжтэй гэж ард түмэн домоглон хэлэлцсээр иржээ. Ажваас их сүрт, арсгар барсгар асга хад ихтэй тул ийн хэлсэн биз ээ. Судрын төгсгөлийн үзвэл Рүдан хийдийн ханчин Агваанпринлайжамц зохиосон ажээ. Рүдэн буюу Раден хийд нь XI зууны эхээр Төвдөд Брондонба хувилгааны байгуулсан хийд болно. Тэгэхээр Агваанпринлайжамц нь энэ хийдээс Их Хүрээнээ залагдан ирсэн бололтой. Их Хүрээний нэгэн эрдэмт лам Агваанпринлайжамцаас Сонгинохайрханы сан сэржим зохион хайрлахыг хүсчээ. Тэгэхэд нь Агваанпринлайжамц, тэр өндөр хар уул их догшин уул юм байна, хатуу үйлийг захиж мусэхэд түргэн бүтээнэ. Энэ уулын эзэн нь хөх үхэр хөлөглөсөн, араа соёо нь зөрсөн, архи нанчид хооглох дуртай, айхавтар хөх өвгөн байна. Бас зарим үед их цэргийн ноёны байдалтай болдог ид шидтэй өвгөн байна гэж айлдаад Сонгинохайрханы сангийн судрыг зохиосон гэдэг.

Уулын санд, Аугаа уужим их газрын эдсийг баригч, хамгийг эрх мэдэлдээ хураагч сайтар талалзан харагдагч, үзэсгэлэнт Өндөрхайрхан өмнөх догшин хар үүлийн дунд, сүрхий хилэнт хар бараан нүүртэй, гартаа улаан торгон молцогтой зэвсэг сэлэм, эрээн мод барьсан хөх өвгөнийг эрин зална гэж бичжээ.

Сонгинот буюу Өндөрхайрханы шивдагуудад сан тахил өргөх ёс есөн хүслийн хур буулгагч хэмээх оршвой

Намо гүрү таа ра наа тха еэ. Эндэх хүрээний баруунаа орших Сонгино /Зонжаа/ уул буюу Өндөрхайрхан хэмээн алдаршсан ууланд оршсон шивдагуудад ариутгал тахил өргөхийг хүсвээс шавар, хүж тэргүүтэн сайхан анхилагт элдэв ариун эд зайг галд шатаагаад:

Ум хэмээн

Ариутгалын зай, тахилын балин гадаад дотоодын нууцын

Аль буй тэргүүтнээр гол болгон адислаад:

Хум,

Агуу уужим газрын эд баригч хамгийг эрхэндээ хураасан

Асар жавхлант, үзэсгэлэнт Өндөрхайрханаар алдаршсан

Энэхүү уулнаа оршсон орны их тэнгэр

Эрхт нөхөд сэлт өөдлөн өөдлөн эл орноо ирэн соёрх.

Өмнөдийн огторгуй дахь шуурган хий адил

Өрвөлзөх догшин хар үүлсийн дунд

Өөрийн лагшин нь харанхуйн өнгө адил

Өгүүлшгүй маш хилэнгийн дүртэй

Торгон молцогтой зэр зэвсэг

Тод эрээн мод мутартаа барьсан

Том хөх үхрийн дээрээс

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

Тонж баясгалангаар залрагчийг уримуу.
Үнэмлэхүйн агаарт өвөрчлөн зорьшгүй ч
Янагуухуйн гадаад дотоод тахилгын үүлэн
Үлэмж дээд эд зай, жансиг үл бүрэлдсэн үүнийг
Дайны тэнгэр, хэвцэг нөхдийг баясгах үүднээс өргөө.
Гайхам бхрүмийн эрдэнээр зуунтаа чимэн хээлсэн
Гагцхүү илтэд үзэсгэлэнт савын доторх билгийн
Галын цогцод сайхан анхилга үнэдийг шатааснаар
Гарсан утаан үүл огторгуйд түгсэн үүгээр
Багш дэгэд гурав, номыг тэтгээчин сахиулсан
Бас онцолбоос Өндөрхайрхан хэмээгдэхийн
Навдаг шивдаг, охин тэнгэр, найман аймаг тэргүүтэн
Насад хоцролгүй ариусан баясаж ханах болтугай.
Таалснаар орны эзэн ба бүрний багш шавийн эрдэм тахилаар
Таагүй улаан, цагаан эдээр тулга тогоо бузар болох
Чулуу ховхлох, газар сэндлэх тэргүүтнийг юун боловч
Чухаг хүлцэн тэвчиж, залбирч хөвгүүнчлэн тэтгэн зохио.
Энэ л орон газрын хүн, малд тусах
Элдэв өвчин хижиг, хяруу мөндөр, ган зудаас
Этгээд муу гай гамшиг

Эрчит догшин аянга цахилгаан буухаас
Энэрэлгүй араатан амьтны хор хөнөөлөөс
Эрхбиш тэжээхүй бүхнийг амирлуулан
Жилийн сайн үр шимийг
Жигд арвижуулан дэлгэрүүлж хайрла.
Эрдэнэ сүрэг, адгуус амьтан арвидахын ам дэлгэрч
Эсэг цагаа, тараг айраг зуны далайтай тэнцэн
Хамаг төрөлхтнийг энх эсэн, орь залууг дэлгэрүүлэх
Харгүй сайн буяны хотол гурван чуулганы үйлсийг зохио
Хамгаас ангид Жавзандамбын энэ хүрээнд
Халамжит бурханы шашны зул машид мандаад
Хотол олны доройтлын харанхуйг сайтар арилгаад
Хосгүй тус амгалангийн гэгээг түгээн хайрла.
Аанай бас энэ зүгийн орноо хуран чуулсан
Алив хүмүүн хаа нэгтээ одож, хаа нэгтээ суух болсон ч
Орон нутаг, зам харгүй, хээр тал бүхэнд ялгалгүй
Онц цагаан үйл бүтээхийг нөхцөлдүүлэн зохио
Эмхэтгэвээс хэвцэг догшин орны тэнгэр та бүхэн
Энэ газрын хүн төрөлхтнийг алгасалгүй сахин аварч
Элдэв дайсны тотгодыг дарж, өнид зүрхний нарыг гийгүүлж
Эээр заяагч тэнгэрийн сахиусыг үл алгасран сахиж
Энгүй хэвцэг Гүн тэнгэрийн их хүчний хувилгаанаар
Эл гурван сансрын хамаг буян хишгийг энд хураагаад
Сав шимийн хамаг дуртмал өнгө, сүр жавхлан

Сайн хутгийн далайгаар газар бүхнээ түгэх болтугай хэмээсэн Их Хүрээний өрнийн сайн жавхлант уул Сонгинот буюу Өндөрхайрханы шивдагуудад ариутгал тахил өргөх ёс есөн хүслэнгийн хур буулгагч хэмээх үүнийг ариун явдалт дээдийн даяанч Лувсаннамжилын дурдсанд Радэн хийд Доржчангийн хувилгааны нэр баригч ханчин Агваанпрэнлайжамц найруулсны бичээч нь Дамдин болой. Сайн буянд орох болтугай.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

Сонгинохайрханы сэржим

Намо гүрү еэ. Эндэх Их Хүрээний өрнө зүгийн уул Өндөрхайрханд оршсон орны тэнгэрт сэржим сэрхийг хүсвээс догшин цагаан архи, ариун алт тэргүүтэн нарийн гурил тавиад адистидлагтун.

Хри:

Гурван ертөнцийн галын бурхан цогт цагийн хар дайсан

Гурван сансрын сүрээр дарагч цогт их догшин гүрү

Гуйвашгүй зарлигийн найман тэнгэрийн чуулганд сэржим өргөснөөр

Гутаггүй их амгалан дээдийн адистидыг бодитой бүтээн соёрх.

Хамгаас онцгой Халх нутгийн газар орон бүхнийг ч

Харьяалан эрхшээгч хүчин төгс Өндөрхайрхан

Хавтай идээр аянга буулгагч эх, хүү, түшмэл сэлт

Ханатал энэ сэржмийг таалж, дайсны тотгорыг эрэн тасал.

Албин шуламс бас бус ад ягчис хийгээд

Ажрах тэнгэр, лус найман аймаг газар дэлхийн эзэн, хатдад

Архи цусан сэржим өргөснөөр хортны зүрхний цусыг юүл.

Эдгөө тэр мэт сэржим ундаа үүнийг өргөснөөр

Эшөөтөн дайснууд тоосон товрог болон дарагдаад

Эчүүхэн ба бүрний нас цог, есөн хүслийн сайн чуулган бүхнийг

Энид хоцроолгүй үтэр түргэнээр арвитган зохио хэмээсэн үүнийг даяанч Лувсаннамжил бээр

Олдсон хүслээр Радэн хийдийн хувилгааны нэр баригч ханчин Агваанпрэнлайжамц найруулбай.

Эн болтугай.

Хар түнгийн орд Хан Тоорил хийгээд хаан Чингисийн хатадын өргөө байжээ



Өст мэргидүүд залуу Тэмүүжиний Бөртэ хатныг уулгалан булааж одсонд тэрбээр Бөртэ хатны инжинд ирсэн хар булган дахыг ганзагалан, Хасар дүүгээ дагуулан Туулын хар түнэд нутаглах Есүхэй баатар эцгийн анд Хэрэйдийн Тоорил ханыг зорин ирдэг тухай "Монголын нууц товчоо"-нд өгүүлдэг. Хэрэйдийн Тоорил ханы сууж асан тэрхүү орд өргөөний суурь нь эдүгээгийн Сонгинохайрхан дүүргийн нутаг, Сонгинын булангийн доохно орших туурь мөн гэдгийг эрдэмтэд баталжээ. Хожим нь Ван ханыг дарагдсаны дараа Чингис хаан түүний Хар түнгийн ордод өргөөлж байсан гэнэ. Мөн уг орд өргөөнд Чингисийн хатан Есүй, Хулан нар амьдарч байжээ гэж үздэг.

Энэхүү Хар түнгийн ордны тууриас холгүй Сонгино хайрханы Дадарт уулнаас олдсон алтан бүсийг Жамухын алтан бүс гэж эрдэмтэд санал нэгдсэн. Тиймээс Чингис хаан энэ Хар түнгийн ордод морилж ахуйдаа анд Жамухыгаа өөрийнх нь хүссэнээр цус гаргалгүй нөгчөөсөн үйл явдал болсон гэдгийг археологич Д.Наваан нотолдог байна.

Сонгинын булангаас доош орших энэхүү Ван ханы ордны туурь нь хааш хаашаа 360 нумын газар эзлэх бөгөөд эндээс хоёр модон багана, амьтан ургамлын уран сайхан дүрс бүхий барилгын хийц хэсгүүд олджээ. Энд археологийн анхны тандалтыг академич Хөдөөгийн Пэрлээ 1949 онд хийж эрдэм шинжилгээний бүтээл туурвилдаа дурдаж байсан аж. Хар түнгийн ордны тууринд 1966 онд хийсэн удаах судалгаа шинжилгээний багт археологич Д.Наваан багтаж байв. Энэхүү туурийн олдвор сэлтээс үзэхэд барилга, байгууламжийн хийц загвар сэлт нь XIII зууны үед барьж байсан барилга байгууламжтай төстэй боловч Монголын эртний нийслэл Хархорум хотоос ч өмнөх үеийн дорно дахины хосгүй соёлын бүрэлдэхүүн бүхий уран барилгын онцгой үзэгдэл байжээ.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

Ван ханы ордны туурийн хамгийн сонирхолтой олдворт гадна хүрээгээрээ 31 одыг дүрсэлж түүний дотор 13 сар, 12 гарагийг багтаасан дугуй хэлбэрт алтан лит зүй ёсоор тооцогдоно.

2006 онд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Туулын Хар түнгийн орд буюу Ван ханы ордны тууринд дахин малталт хийж нарийвчлан судалсан юм. Энэ малталт судалгаагаар зааны дүрс, зээвадын толгой, сармагчин, арслан зэрэг дорно дахины урлагийн бэлэгдэлт дүрслэл бүхий эд өлгийн зүйл олджээ. Цаашид энэ тууринд бүрэн гүйцэд малталт хийж судалгаанд хамруулахын зэрэгцээ тэр үеийн хэлбэр хийцийг илтгэхүйц барилгын цогцолбор барьж байгуулан гадаадын аялагч, жуулчдыг даллан дуудах хэтийн төлөв ч бий.

Толгойтын Зүүн салаа, Тахилт нуурын дэнжид Хүрээ суурьшиж байв

Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг, Их Монгол уулын өвөрт орших Ширээт цагаан нуурт Өндөр гэгээн Занабазарыг таван настайд нь Монголын шашны тэргүүн анхдугаар Богд Жавзундамбаар өргөмжилж Шар бөсийн орд барьж өгснөөр нийслэл Улаанбаатар хотын үүсэл тавигдсан гэдэг. Тэр цагаас хойш Хутагтын Хүрээ хорь гаруй удаа нүүдэллэсний эцэст 1747 онд Богд хан уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулуудын дунд Алтан тэвшийн хөндийд бууриа засчээ. Ийнхүү Хүрээ дөрвөн уулын дунд хатан Туулын хөвөөнд ханаа шийрлэснээс хойш ойр зуурхан нүүдэллэсэн түүхтэй. Нэгэн үе Хүрээ Алтан тэвшийн хөндийн нэгээхэн зах сэжүүр Толгойтын Зүүн салааны адагт Тахилт нуурын хойд дэнжид суурьшиж байжээ. Энэ үед Хүрээний лам хувраг, сүм хийдүүд Сэлбэд, харин Жавзундамба хутагтын өргөө Тахилт нуурт байсан аж. Жавзундамба хутагтын өргөө Толгойтын Зүүн салааны адагт, Туул голын шар, цагаан сүм харагдахуйц газар байсан тухай гадаадын жуулчид бичсэн байдаг. Энэ нь газрын баримжаагаар бол Толгойтын тоосгоны үйлдвэрийн зүүн урд дэнж болов уу гэж судлаач О.Пүрэв, С.Шагдар, С.Ичинноров, О.Сүхбаатар нар таамагладаг тухайгаа “Нийслэлийн өв соёл” номд бичсэн байдаг. Мөн номд өгүүлснээр, 1955-1956 оны үед Толгойтын Зүүн салаанд Баян хошууны зүүн урд орших Тахилт нуур байнгын устай, хойт эрэг дээр нь бичээс бүхий багавтар хөшөөтэй байсныг эрдэмтэн О.Сүхбаатар багадаа харж байжээ. Уг хөшөөний бичиг нь Монгол, Манж, Төвд бичиг алин болохыг тэрбээр мэдээгүй аж. 1971 оны үед Тахилт нуурын ус маш их багассан, хөшөө нь зоолттой хэвээр байсан гэнэ. 1970-аад оны эцсээр Баянхошуунд гэр хороолол бий болоход нуур ширгэж, хөшөө ч алга болсон байна.

Хоёрдугаар Богд Жавзундамба Сонгинохайрханы өвөрт мэндэлжээ

Сонгинохайрханы Өгөөмөрийн шар булан хэмээх тохой аралд дархан Чин ван Дондовдоржийнх нутаглаж ахуйд Халхын хоёрдугаар Богд Жавзундамба Лувсандамбийдоми мэндэлсэн түүхтэй. Тиймээс ардууд,

Өгөөмөрийн шар тохойд

Өнгө бүрийн цэцэг дэлгэртнэ

Өндөр дээд төрөл язгууртны ордонд

Өвгөн хутагт маань мэндэллээ дээ хэмээн дуулцгаадаг байжээ.

Тэгээд Туулын хойд дэнж дээр Баярт толгой гэдэг газар Уртнасан гавж хоёр жижиг сүм барьж чулуугаар бурхан багшийн найман суваргыг маш урнаар бүтээлгэн залсан аж. Нурж баларсан найман суваргыг хожим 1950 онд гэвш Данигай лам авчирч Гандантэгчинлэн хийдийн цагаан суваргыг тойруулан тавьсан гэдэг.

Талын язгууртны алтан бүс ба “Бургасан сүргийнхэн”

Туулын урд буланд Морин уулын гацаа гэж бий. Тэнд улсын анхны мал эмнэлгийн газар байгуулагдаж байжээ. Сонгинохайрхан уулын хойд энгэрт Хамбын өвөлжөө, Хамбын булаг, зүүн урд бургасанд улсын амралт буй. Сонгинохайрхан уулын орчим, Туулын савд Хүннүгийн булш хиргэсүүр олон бий. 1988 онд доктор Д.Наваан уулын өврийн булшнаас сумын зэв, дуут товруу, алтан чимэг бүхий бүс олжээ. XIII зууны талын язгууртны эдлэл хэрэглэл болох энэхүү олдвор, ялангуяа алтан чимэгтэй бүсийг Чингис хаан, Жамуха нарын солилцсон алтан бүс байж магадгүй хэмээн таамагладаг.

Сонгинохайрхан уулын өвөр Туул голын дагуу “Бургасан сүргийнхэн” хэмээгдсэн бургасан хана, араг савар, уурганы үзүүр, тэмээ хайнаг, сарлагны дөр мод хийж худалдан амь зуудаг хэсэг айл байжээ.

Жаргалант тосгон журамт цэргийн түүхийн өлгий

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо буюу Жаргалант тосгон бол Ардын хувьсгал хийгээд Ардын журамт цэргийн түүхтэй салшгүй холбоотой нутаг. Тиймээс ч социализмын үед энэхүү Жаргалантыг Партизаны сангийн аж ахуй хэмээн нэрийдэж байсан нь учиртай. Түүх өгүүлбээс 1921 онды долдугаар сард жанжин Д.Сүхбаатараар удирдуулсан Монгол ардын журамт цэрэг Нийслэл Хүрээг чөлөөлөхөөр явах замдаа эдүгээгийн Жаргалант тосгон байгаа газарт хоноглосон аж. Ингээд маргааш өглөө нь Ардын журамт цэрэг болон тэдэнд хүч нэмэгдүүлэн ирсэн оросын улаан армийнхан гурван замаар Хүрээ рүү орсон байна. Ингэхдээ Сүх жанжны удирдсан Ардын журамт цэрэг гол замаар нь буюу Сонгинохайрхан дүүргийн нутаг Богдын даваагаар давж Нийслэл Хүрээнд орж иржээ. Харин баруун, зүүн гарын хоёр замаар нь улаан армийнхан Хүрээ рүү нэвтэрсэн гэдэг.

Ийнхүү жанжин Сүхийн үйл хэрэг, журамт цэргийн түүхийг өгүүлэн байдаг Жаргалант тосгон 2007 онд 30 жилийн ойгоо тэмдэглэж байгаа юм. Энэ ойнх нь үеэр Сонгинохайрхан дүүргийн Хөг хаягдлын үйлчилгээний сангийн захирал, бэлтгэл хурандаа Р.Нэргүй санаачлан Жаргалант тосгоны соёлын төвийн өмнөх талбайд Нийслэл Хүрээг чөлөөлөх замдаа Ардын журамт цэрэг хоноглосон үйл явдлын дурсгалд зориулсан самбар босгон их жанжны баримлыг босгож түүхэн үйл явдлыг мөнхжүүлсэн байна.

Алтан тэвшийн домог

Эрт урьд цагт энэ замбуулин хорвоо үүсэж байх үед юм гэнэ. Хан уул нэрээ олоогүй, Хатан туул минь урсаж эхлээгүй байх тэр цагт эндхийн жижигхэн булгийн дэргэд Лусын хааны хайртай ганц охин таван дагуул үзэсгэлэнтэй охидынхоо хамт тэнгэрээс бууж ирээд авч ирсэн эрдэнийн алтан тэвшээрээ тэр булаг шанднаас ус хутган, усаа цалгиулан цацруулан дуулж, бүжиглэж тоглохыг мангас шулмын хаан хараад маш их хилэгнэжээ. Тэрбээр, энэ бол бурханы явуулга, Лусын охин ирж эрдэнийн алтан тэвшээр ус хутган тоглож байгаа нь энд амьдрал үүсгэж хүн суурьшуулах гэж Лусын хаан охиноо явуулсан хэрэг. Энэ эрдэнийн алтан тэвшээр цацрах ус шиг ус булаг ундарсан ургамал цэцэг тэгш үзэсгэлэнтэй нутаг үүсэж хүн амьтан суурьших нь хэмээн мэд уурлан атаат сэтгэл төрж таван чөтгөрөө дуудаж ирүүлээд нэг дэх чөтгөрт ингэж хэлжээ.

—Чи урд талаас нь очиж тэр булаг дээр эрдэнийн алтан тэвшээр ус хутган тоглож байгаа Лусын охин, түүнийг дагаж яваа таван охиныг айлгаж сандарган эрдэнийн алтан тэвшийг нь авчир гэж явуулжээ. Энэ үед Лусын охиныг дагаж яваа таван охины хамгийн бага их мэргэн үзмэрч охин тоглож явснаа гэнэт ингэж хэлжээ.

—Яана аа, биднийг мангас шулмын хаан харчихлаа. Бид хэдийг хорлож алтан тэвшийг авах чөтгөрөө явууллаа, одоо яах вэ гэхэд, Лусын охины дагуул таван охины эгчмэд нэгдэх охин ингэж хэлжээ.

—Ном муутай тойн хүнээс ном эрдэмгүй гөрөөчин эр дээр гэдэг үг бий. Би анчин гөрөөчин болж хөх гээд анчин эр болон хувирч овоохой босгож хоолоо хийгээд хүлээж суужээ. Нэг дэх чөтгөр мэд саваагүйтэн исгэрч орилж айлгах гэж ядаад овоохойг нь шөргөөж цоолж шагайтал халуун тасгай шөлөөр нүдийг нь сохлоод алчихаж гэнэ. Нэг дэх чөтгөрөө нүдээ сохлуулж алагдсанд мангас шулмын хаан уурлахын ихээр уурлаж хоёр дахь чөтгөрөө дуудаж ингэж хэлжээ.

—Чи миний далан алд төмөр шилбүүрийг авч тэр олон бэлчиж яваа зээрийг тас ороолгон мангас шулмын хаан Лусын охин, түүнийг дагаж яваа таван охиныг дайруулан алаад эрдэнийн алтан тэвшийг нь авчир гэж явуулсныг тав дахь охин бас мэдээд мангас шулмын хаан хоёр дахь чөтгөртөө далан алд төмөр шилбүүр өгч үй олон зээрийн сүргээр биднийг дайруулан алж эрдэнийн алтан тэвшийг мангас шулмын хаан явууллаа, одоо яана аа гэхэд хоёр дахь охин ингэж хэлжээ.

—Зээрийн сүрэг олон ч гэлээ зэгэл саарал ганцдахгүй гэдэг. Би хөх чоно болж хөөе гээд мангас шулмын хаан саарал чоно болон хувирч улин хөөхөд олон зээр эргэн дайрч зугтахдаа далан алд төмөр шилбүүртэй чөтгөрийг нь дайраад алчихаж гэнэ.

—Хоёр дахь чөтгөрөө алдсан мангас шулмын хаан уурлахын ихээр уурлаж арга ядахдаа гурав дахь чөтгөрөө дуудаж ингэж хэлжээ.

—Чи эрдэм номтой түшмэлийн дүрээр тэдэнтэй ном хаялцана. Лусын охин, түүнийг дагалдаж мангас шулмын хаан таван охин дуулж дэвхцэхээс өөр юу хийж чадав гэж. Хэрэв чи тэдэнд буруу зөрүү ярьж, мангас шулмын хаан хариулж чадахгүй ялагдвал чи газар дээрээ аянганд нэрвэгдэнэ. Тэд ялагдвал тэд

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 15 ЖИЛ

аянганд ниргэгдэж тэдний алтан тэвш минийх болно гэсэн хатуу тангарагтай ном хаялцуулахаар явуулжээ.

Тав дахь охин үүнийг бас мэдээд ингэж хэлжээ.

-Мангас шулмын хаан бидэн рүү гурав дахь чөтгөрөө ном эрдмийн түшмэл болгон хувиргаж, ном хаялцуулахаар явуулж байна. Хэрвээ бид буруу зөрүү хариу өгч үг алдвал аянганд нэрвэгдэж, газар дээрээ үхэж алтан тэвшээ алдана гэж санаа алдан хэлэхэд гурав дахь охин ингэж хэлжээ.

-Эрдэм номонд муухан ч гэлээ би элдэвтэй тэр түшмэл болсон чөтгөртэй ном муухан хаялцъя гээд явжээ. Мангас шулмын хааны түшмэл болсон чөтгөр гурав дахь охинтой уулзаж болзлоо хэлж хэн нь эхлэхээ шодоход мангас шулмын хааны түшмэл болсон чөтгөр эхлэн асуух болжээ. Мангас шулмын хааны түшмэл болсон чөтгөр,

-Бурхан бурхан гэх бурхны чинь эцэг хэн бэ гэж асуухад охин,

-Сэтгэл гэвэл, түшмэл болсон чөтгөр ихэд гайхан тэгвэл сэтгэлийн чинь эцэг хэн бэ гэхэд гурав дахь охин,

-Мөнх хөх тэнгэр гэхэд чөтгөр ихэд баярлан, тэнэг минь тэр бурхны чинь эцэг манай шулмын хаан гэнгүүт аянга мангас шулмын хааны түшмэл болсон чөтгөрийг ниргэчихэж гэнээ.

Гурав дахь чөтгөрөө аянганд ниргүүлсэн мангас шулмын хаан уурлахын ихээр уурлаж дөрөв дэх чөтгөрөө дуудаж ингэж хэлжээ.

-Чамайг зуу дахин хувирах шидэт баатар болгон явууллаа. Чи Лусын хааны охин, түүнийг дагаж яваа таван дагуулыг алаад эрдэнийн алтан тэвшийг авчир гэж явуулжээ. Тэгж явуулахдаа хохимой толгойн дуулга өмсгөж, чиний хохимой толгойн дуулган дунд байгаа өндгөн чинээ хар мэнгэ, хар үсийг чинь харваж чадаагүй үед чи үхнэ гэж үгүй. Иймд чи бүү ай, бүгдийг устгаж алтан тэвшийг ав гэж дахин дахин хэлжээ. Энэ явдлыг тав дахь охин бас мэдэж ингэж хэлжээ.

-Мангас шулмын хаан зуу дахин хувилах шидтэй түмэн хүний хохимой толгойн дуулгатай, дуулганы элгэн голд чигчийн чинээ хар мэнгэ, хар үстэй баатраа явууллаа. Энэ баатрын хар мэнгэ, хар үсийг харваж чадаагүй хэн ч дийлэхгүй, одоо яана гэхэд дөрөв дэх охин,

-Бүү ай, харанхуй шөнө хар батганын толгой хага харвах баатар би биш ч гэсэн харвая гээд харваад алчихаж гэнэ.

Мангас шулмын хаан дөрөв дэх чөтгөрөө алуулсанд уурлахын ихээр уурлаж тав дахь охины мэргэн ид шидтэйг мэдэж гаслахын ихээр гаслаж өөрийгөө хараан цамнан уурлаж тав дахь чөтгөрөө дуудаж ингэж хэлжээ.

-Чамайг би хэнд ч үзэгдэхгүй, хөх өвсөнд хөх зүү мэт явах хөх могой болгон хувиргаж, Лусын охин, түүнтэй яваа таван охиныг алуулахаар явууллаа. Тэр дундаа тав дахь бага охиныг хамгийн түрүүнд ал. Тэгэхэд бусад нь яаж ч чадахгүй гэж хэлээд явуулжээ.

Өдөржин шөнөжин айн түгшсэн Лусын охин түүнийг дагалдаж яваа таван охин ядарч, үүр шөнөөр нүд нь анилдаж байтал тав дахь охин хашгиран босон харайж, хариугүй хатгах гэж байсан хар эрээн могойн толгой сүүлийг базан тэлж Лусын охин чинийхээ хаш цагаан орд харшийн чинь хаалга үүдийг сахих ерөөлтэй хангарьд нь би боллоо гээд нисээд явчихжээ. Үүнээс үүдэн хүрээ хот хангарьд сүлдтэй болсон гэнэ.

Нэг дэх охин нь анхны аюулыг зайлуулснаараа урд уулын савдаг анчин эр больё гээд явчихаж гэнэ. Тэр цагаас хойш Богд уул ан гөрөөндөө харам үгүй ч худал хулгай тогтдоггүй, анчин эр савдагтай болсон гэдэг.

Хоёр дахь охин нь хөнөөлийг хөөж хөх чоно болсон учир хайрхан уулыг чинь харж хамгаалах савдаг сахиус нь больё гээд явчихаж гэнэ. Тэр цагаас хойш Сонгино уул догшин хөх чоно савдагтай уул болсон гэнэ.

Гурав дахь охин нь эрдэмтэй түшмэл болж ирсэн гурав дахь чөтгөрийн хөнөөлийг дарсан учир эрдэм номыг дээдэлсэн эрдмийн савдаг болж Чингэлтэй уулыг чимж явъя гээд явснаас Чингэлтэй уулыг ном эрдмийн улс шүтдэг болсон гэнэ.

Дөрөв дэх охин нь баруун өмнөөс байлдахаар ирсэн баатрын хорлолыг арилгаж чадсан би Баянзүрх уулын чинь савдаг больё гээд явснаас Баянзүрх уул баатар эрийн зүрх мэт цэрэг эрсэд ээлтэй уул болсон гэнэ. Ингэж Лусын охиныг дагаж ирсэн таван охин буцаж чадахгүй болсонд Лусын охин алтан тэвшээ урд ууланд тавьснаас Ширээ тэвш хэлбэртэй уул, алтан тэвшийн хөндий гэж ам бүрээс нь ус булаг ундарсан үзэсгэлэнтэй сайхан хөндий үүссэн гэнэ.